

**ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРИЙН
ТАЛААРХ ОЙЛГОЛТ & ОЛОН УЛСЫН
ХОЛБОГДОХ ХЭМ ХЭМЖЭЭ**

ЭНЭХҮҮ ИЛТГЭЛД:

- ❖ Хүүхдийн хөдөлмөрийн тухай ойлголт
- ❖ Хүүхдийн хөдөлмөрийн талаарх олон улсын хэм хэмжээ (конвенц, нэмэлт протокол, зөвлөмж)

ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРИЙН ТАЛААРХ ТОДОРХОЙЛОЛТ

- ❖ **Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн тухай ОУХБ-ын 182 дугаар конвенцид**
 - ❖ 179 орон баталсан
 - ❖ Монгол Улс 2001 онд нэгдсэн
- ❖ **Ажилд авах насны доод хязгаарын тухай ОУХБ-ын 138 дугаар конвенц**
 - ❖ 167 орон баталсан
 - ❖ Монгол Улс 2002 онд нэгдсэн

ОУХБ-ЫН 182 ДУГААР КОНВЕНЦИЙН ТОДОРХОЙЛОЛТ

- ❖ Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэр гэдэгт:
 - а) боолчлолын бүх хэлбэр болон хүүхдийг худалдах, дамжуулан худалдах, өрийн төлөөс, хамжлагын албат болгох, хүчээр буюу албадан хөдөлмөрлүүлэх зэрэг боолчлолтой төстэй үйл ажиллагаа;
 - б) хүүхдийг биеэ үнэлэх, садар самуун сурталчилгааны үйлдвэрлэл буюу садар самуун үзүүлбэрт ашиглах, зуучлах, санал болгох;
 - в) хүүхдийг мансууруулах бодис үйлдвэрлэх, хил дамжуулан худалдах зэрэг хууль бус үйл ажиллагаанд ашиглах, зуучлах, санал болгох;
 - г) ажлын шинж чанар, түүнийг гүйцэтгэх нөхцөл нь хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд хор нөлөө үзүүлэх ажил;

ОУХБ-ЫН 182 ДУГААР КОНВЕНЦИЙН ТОДОРХОЙЛОЛТ

- ❖ (конвенцийн зорилгод нийцүүлэн) “Хүүхэд” гэсэн нэр томъёо нь 18 насанд хүрээгүй бүх хүнд хамаарна.

ОУХБ-ЫН 138 ДУГААР КОНВЕНЦ:

- ❖ Ажилд авах насны доод хязгаар-15 нас (бүрэн бус дунд боловсрол эзэмших нас байх)
 - ❖ Хөгжиж буй орон - эхний үед 14 нас
- ❖ Хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй **аюултай ажил** эрхлэх насны доод хязгаар-18 нас
- ❖ **Хөнгөн ажил** хөдөлмөр эрхлүүлэхийг зөвшөөрч болох нас - 13/15 нас

ОУХБ-ЫН 182-Р КОНВЕНЦ & 190-Р ЗӨВЛӨМЖ

- ❖ **Аюултай** ажил гэдэгт ажлын шинж чанар, түүнийг гүйцэтгэх нөхцөл нь хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд хор нөлөө үзүүлэх ажлыг хамруулна.
- (a) биеийн, сэтгэл зүйн, бэлгийн хүчирхийлэлд өртөх нөхцлийг бий болгох магадлалтай ажил;
- (б) газрын гүнд, усан дор, хэт өндөрт, болон хавчигдмал орон зайд хийгддэг ажил;
- (в) аюултай машин, тоног төхөөрөмж ашигладаг, буюу тэдгээр төхөөрөмж дээр гүйцэтгэдэг ажил;
- (г) аюултай бодистой ажиллах, хэт өндөр буюу нам даралттай орчин, хэт шуугиантай орчинд ажиллах
- (д) эрүүл мэндэд хор хөнөөл учруулахауйц ажлын хүнд нөхцөлд ажиллах (хэт олон цаг, шөнийн цагаар ажиллах, нэн хүнд зүйл өргөх, ачих, буулгах гэх мэт)

ОУХБ-ЫН 138 ДУГААР КОНВЕНЦ

❖ **Хөнгөн** ажил, хөдөлмөр нь:

(а) эрүүл мэнд, өсөлт хөгжилд хортой нөлөө үзүүлэхгүй ажил,

(б) хичээлдээ суухад саад учруулахгүй ажил


(в) эрх бүхий байгууллагаас батласан мэргэжлийн чиг олгох, мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрт хамрах болон олсон мэдлэгээ ашиглах явцад нь саад учруулахгүй байх шаардлагыг хангасан ажил байх ёстой.

АЖИЛД АВАХ НАСНЫ ДООД ХЯЗГААР


Оухб-ын 138 дугаар конвенцийн шаардлага

	ҮНДСЭН ШААРДЛАГА	ХӨГЖИЖ БУЙ ОРНУУДАД ЗӨВШӨӨРЧ БОЛОХ ХЭМ ХЭМЖЭЭ
Насны доод хязгаар	15 нас (бүрэн бус дунд боловсрол эзэмших наснаас ДООШГҮЙ байх)	14 нас
Аюултай ажил	18 нас	Зайлшгүй (өөр сонголт/хувилбар байхгүй)
Хөнгөн ажил	13-15 нас	12-14 нас

ТООН ҮЗҮҮЛЭЛТ



ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨР (САЛБАРААР)



ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРИЙН ТЭВЧИШГҮЙ ХЭЛБЭРҮҮДИЙГ УСТГАХАД ЧИГЛЭСЭН АРГА ХЭМЖЭЭ

- ❖ Бодлогын түвшинд хэрэгжүүлэх арга хэмжээ
- ❖ Судалгаа, дүн шинжилгээ
- ❖ ХХТХ-д хамрагдсан хүүхдүүдийг хөдөлмөрөөс хөндийрүүлэх, албан/албан бус боловсролд хамруулах, холбогдох үйлчилгээнд зуучлах, мэргэжлийн боловсрол, сургалтын хөтөлбөрүүдэд хамруулах, аюулгүй хөдөлмөр эрхлэлт
 - 4/5-13/14 насны бүлэг
 - 15-18 насны бүлэг
- ❖ Сурталчилгаа, ойлголтыг нэмэгдүүлэх арга хэмжээ

ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРИЙН ТЭВЧИШГҮЙ ХЭЛБЭРИЙГ ЯАГААД УСТГАХ ЁСТОЙ ВЭ?

- ❖ Хүний эрхийг хамгаалах
- ❖ Эдийн засгийн өсөлтийг хангах (бараа үйлдвэрлэл, нийлүүлэлтийн сүлжээн дэх хүүхдийн хөдөлмөр)
- ❖ Хүний хөгжил/Тогтвортой хөгжлийг хангах үндэс

МОНГОЛ УЛС ДАХЬ
ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРИЙН
НӨХЦӨЛ БАЙДАЛ &
ҮНДЭСНИЙ ХУУЛЬ
ТОГТООМЖУУД

ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРИЙГ ТООЦОХ АРГАЧЛАЛ

“Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал”-ыг Үндэсний статистикийн хороо, НХХ-ийн сайдын хамтарсан тушаалаар 2009 онд баталсан.

Энэхүү аргачлалаар “Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт”-ийг

- Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа 5-11 насны,
- Хөнгөн ажлыг 7 хоногт 14-өөс дээш цагаар хийж байгаа 12-14 насны,
- 7 хоногт 43 ба түүнээс дээш цагаар ажиллаж байгаа 15-17 насны бүх хүүхдийг тус тус хамруулна.

ТАЙЛАН, ИЛТГЭЛ, ЗӨВЛӨМЖ

- НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцийн хэрэгжилтийн талаарх Монгол Улсын үндэсний тавдугаар тайлан илтгэл. 2009 , 2015
- Хүүхдийн эрхийн тухай конвенцийн хэрэгжилтийн асуудлаар НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Хороонд илгээх хөндлөнгийн илтгэл - 2010, 2015., ТББ-ууд
- Монгол Улс дахь хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд -2008., ХЭҮК , ОУХБ
- ОУХБ-ын 182 болон 138 дугаар конвенцийн хэрэгжилтийн тайлан-2008., Монгол Улс
- АНУ-ын Төрийн департаментын зөвлөмжүүд. 2013, 2014, 2015

СУДАЛГААНУУД:

- Бичил уурхай дахь хүүхдийн хөдөлмөр. ГБХЗХГ. 2016
- Хаврын хурдан морины уралдаан дахь хүүхдийн эрх, Монголын хуульчдын холбоо, Эрх зүйн судалгааны төв. 2016
- Барилгын салбар дахь хүүхдийн хөдөлмөрийн асуудлыг тодорхойлох түргэвчилсэн судалгаа, ХТҮГ, ОУХБ. 2015
- Хурдан морь унаач хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал. ХТҮГ. 2010
- Хүүхдийн хөдөлмөрийн судалгаа. 2004, 2008, 2012
- Ажиллах хүчний судалгаа. ҮСХ, ОУХБ. 2009
- Монгол Улс дахь Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд. ХЭҮК. 2008

Хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдийн тоо

- Статистикийн үндэсний хороо, Ажиллах хүчний судалгаа,
- Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд, ХЭҮК, ОУХБ
- Монголын хүүхдийн хөдөлмөрийн судалгаа,



Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын хяналт, шалгалт-2012 онд 1200 хүүхэд илэрсэн.

ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРИЙН СУДАЛГАА

- Монголын хүүхдийн хөдөлмөрийн судалгаа, 2003-2004. ҮСХ 65580
- Монголын хүүхдийн хөдөлмөрийн судалгаа, 2003-2004. ҮСХ 71330
- Монголын хүүхдийн хөдөлмөрийн судалгаа, 2011-2012. ҮСХ 93968
- Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд. 2008. ХЭҮК

ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРИЙН СУДАЛГАА 2011-2012 ОН

➤ 5-17 насны нийт хүүхдийн 15,9 хувь эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж байна.

➤ Тэдний 54,1 хувь хөвгүүд, 45,9 хувь охид байна.

Эдгээр хүүхдийг насны бүлгээр авч үзвэл:

➤ 5-9 насныхан 18,8 хувь

➤ 10-11 насныхан 14,5 хувь

➤ 12-14 насныхан 30,8 хувь

➤ 15-17 насныхан 35,9 хувийг эзлэж байна.

➤ Ажил эрхэлж байгаа хүүхдийн 0,7 хувь өрхийнхөө орлогыг дангаар бүрдүүлдэг байна.


ОУХБ-ЫН ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРИЙН ТЭВЧИШГҮЙ ХЭЛБЭРИЙГ УСТГАХ ОЛОН УЛСЫН ХӨТӨЛБӨР

- Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн тухай 182-р конвенцид нэгдэн орсон гишүүн орнуудын хүчин чармайлтыг дэмжих зорилгоор АЙПЕК нь тодорхой хугацааны дотор хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах хөтөлбөрийг хэрэгжүүлдэг.
- Монгол Улсад 1999 оны 11 сараас эхлэн 2009 он буюу дунд үе хүртэл 2 үе шаттайгаар хэрэгжсэн.

Зорилго:

- Хүүхдийн хөдөлмөрийн асуудлаар гурван талт хамтын ажиллагааны дүнд төрийн бодлогод нөлөөлөх;
- Хүүхдийн хөдөлмөрийн асуудлыг шийдвэрлэх төрийн ба төрийн бус байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх;
- Хүүхдийн хөдөлмөрийн асуудлаарх судалгаа мэдээллийг сайжруулах;

**ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРИЙН АСУУДЛААР
МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН**



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖ

- **Хүүхдийн эрхийн тухай хууль** (2016 оны 02 дугаар сарын 05-ны өдөр батлагдав.)
- **Хүүхэд хамгааллын тухай хууль** (2016 оны 02 дугаар сарын 05-ны өдөр батлагдав.)
- **Хөдөлмөрийн хууль** (1999 оны 05 дугаар сарын 14-ний өдөр батлагдав.)
- **Эрүүгийн тухай хууль** (2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр батлагдав.)
- **Зөрчлийн тухай хууль** (2017 оны 05 дугаар сарын 11-ны өдөр шинэчилсэн найруулга батлагдав.)
- **Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт** (2016 онд шинэчлэв)
- **Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, өргөх зөөх ачааны зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 4970:2000**
- **Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах үндэсний хөтөлбөр (2012-2016 он)**
- **Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр (2017-2021 он)** Засгийн газрын 2017 оны 270 дугаар тогтоолоор баталсан.

ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬ

Хөдөлмөрийн тухай энэхүү заалт нь жагсаалтанд ороогүй ажлуудыг буюу хөнгөн ажлуудыг тус хуулинд заасан цагаар ажил эрхлэхийг зөвшөөрдөг.

- Насанд хүрээгүй хүний хөдөлмөр:
- 16 насанд хүрсэн хүн хөдөлмөрийн гэрээ байгуулах эрхтэй.
- 15 насанд хүрсэн хүн эцэг, эх буюу харгалзан дэмжигчийн зөвшөөрөлтэйгээр хөдөлмөрийн гэрээ байгуулж болно.
- Мэргэжлийн баримжаа, ажлын дадлага олгох зорилгоор 14 насанд хүрсэн хүнтэй эцэг эх, асран хамгаалагч болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлтэйгээр хөдөлмөрийн гэрээ байгуулж болно.
- Дээр дурьдсанаас бусад тохиолдолд насанд хүрээгүй хүнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулахыг хориглоно.

НАСАНД ХҮРЭЭГҮЙ ХҮН ЭРХЛЭХИЙГ ХОРИГЛОСОН АЖИЛ

1. Насанд хүрээгүй хүнийг оюун ухааны хөгжил, эрүүл мэндэд нь харшлах хөдөлмөр эрхлүүлэхийг хориглоно.
 - Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 1999 оны А/204 тоот тушаалын 2 дугаар хавсралтаар Насанд хүрээгүй ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтыг баталсан
 - 2008 онд Нийгмийн хамгаалал,хөдөлмөрийн сайдын тушаалаар шинэчилсэн
 - 2016 онд Хөдөлмөрийн сайдын А /36 дугаар тушаалаар шинэчлэн баталсан.
2. Насанд хүрээгүй ажилтныг хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлтэй ажилд ажиллуулахыг хориглоно.

АЮУЛТАЙ АЖЛЫГ ТОДОРХОЙЛОХДОО

№	Шалгуур үзүүлэлт	Нөхцөлүүд
1	Хүүхдийн нас	
2	Төрөл, шинж чанараараа хүүхдийн эрүүл мэнд, хөгжилд сөрөг нөлөө үзүүлэх	
3	Хүүхдэд үзүүлж болох эрсдэлийг нэмэгдүүлэх хүчин зүйл	Байгаль цаг агаарын, Ажлын нөхцөлийн
4	Хүүхдийн сэтгэл зүй, ёс суртахууны хувьд үзүүлэх нөлөөлөл	
5	Хүүхдийн суралцах үйл явцад нөлөөлөх байдал	
Монгол Улсын хууль тогтоомж, стандарт болон холбогдох конвенцийн ямар зүйл заалт зөрчигдөж байгаа эсэх		

ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРИЙН
ХУУЛЬ ТОГТООМЖ ЗӨРЧИГЧДӨД
ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬ

109 дүгээр зүйл. Насанд хүрээгүй хүний хөдөлмөр

109.1.16 насанд хүрсэн хүн хөдөлмөрийн гэрээ байгуулах эрхтэй.

109.2. Энэ хуулийн 109.5-д харшлахгүй бол 15 насанд хүрсэн хүн эцэг, эх буюу харгалзан дэмжигчийн зөвшөөрөлтэйгээр хөдөлмөрийн гэрээ байгуулж болно. /Энэ хэсгийг 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

109.3. Мэргэжлийн баримжаа, ажлын дадлага олгох зорилгоор 15 насанд хүрсэн хүнтэй эцэг эх, асран хамгаалагч болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлтэйгээр хөдөлмөрийн гэрээ байгуулж болно. /Энэ хэсэгт 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

109.4. Насанд хүрээгүй хүнийг оюун ухааны хөгжил, эрүүл мэндэд нь харшлах хөдөлмөр эрхлүүлэхийг хориглоно.

109.5. Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтыг хөдөлмөрийн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн батална.

109.6. Энэ хуулийн 109.1, 109.3-т зааснаас бусад тохиолдолд насанд хүрээгүй хүнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулахыг хориглоно. /Энэ хэсгийг 2003 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар нэмсэн, энэ хэсэгт 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

141 дүгээр зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

- 141.1. Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.
- 141.2. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.
- 141.3. Энэ хуулийг зөрчсөн үйлдлийн улмаас ажилтны эрүүл мэндэд гэм хор учирсан бол Иргэний хуулийн гэм хорын тухай холбогдох заалтаар хохирлыг нөхөн төлүүлнэ.
- 141.4. Ажилтны цалин хөлсийг тогтоосон хугацаанд олгоогүй, саатуулсан нь нотлогдсон тохиолдолд хожимдуулсан хоног тутамд 0,3 хувийн алданги ажил олгогчид шүүх ногдуулж, ажилтанд олгоно. /Энэ зүйлийг 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ

6.20	Хүүхдийн эрхийг зөрчих	торгууль
1.	1.1. Хүүхдийг хувцас, хоол хүнс, орон байраар зориуд гачигдуулсан; 1.2. Хүүхдэд эрүүл ахуйн шаардлагад нийцээгүй хоол хүнсний зүйлийг хэрэглүүлсэн; 1.3. Хүүхдийн сурч боловсрох, хөгжих, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хязгаарласан:	50 х 500
3.	3.1. Хүүхдийг өөрийнх нь ба эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрөлгүйгээр мэдээлэл, сурталчилгаанд ашигласан; 3.2. Бусад хэлбэрээр хууль бусаар нэрийг нь барьж, ашиг олох, эрүүл мэнд, амь нас, нэр хүндэд нь харшлах, эсхүл аюул учруулах тоглоом, наадамд оролцуулсан бол:	100 х 1000
7.	Хүүхдийн эрхийг хангах талаар эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	200
9.	Хүүхдийн бие махбодод халдсан, эсхүл үл хайхарсан, эсхүл хүүхдийн дэргэд архидан согтуурсан, мансуурсан, хүчирхийлэл үйлдсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	300

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ
2017 оны 05 дугаар сарын 11-ний өдөр

Хуулийн 10.16 дугаар зүйл. Хөдөлмөрийн тухай хууль зөрчих

2. Насанд хүрээгүй хүнээр зөвшөөрөгдсөн хэмжээнээс илүү хүнд ачааг өргүүлсэн, зөөлгөсөн, насанд хүрээгүй хүнийг шөнө, амралтын өдөр, эсхүл илүү цагаар ажиллуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж **хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр** торгоно.

ЭРҮҮГИЙН ТУХАЙ ХУУЛЬ

д/д	16.1 ХҮҮХДИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ	ТОРГОХ ТООЦОХ НЭГЖ	ЗОРЧИХ ЭРХ 7х, сар, жил	ХОРИХ
1.	16.1 дүгээр зүйл. Хүүхдийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулах 16.1 дүгээр зүйл.Хүүхдийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулах	-	1-5 жил	1-5 жил 2-8 жил
2.	16.2 дугаар зүйл. Хүүхдийг согтуурах, мансуурах, донтох байдалд татан оруулах	5400-27000 нэгж	1-5 жил	5-12 жил
3.	16.4 дүгээр зүйл. Хүүхдээр гуйлга гуйлгах 16.4 дүгээр зүйл. Хүүхдээр гуйлга гуйлгах	240-480 цаг хүртэл	1-5 жил	1-5 жил
4.	16.6 дугаар зүйл. Хүүхэд худалдах 16.6 дугаар зүйл. Хүүхэд худалдах	10,000-40,000 нэгж	-	2-8 жил
5.	16.8 дугаар зүйл. Хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах <i>/Энэ хэсэгт 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/</i>	2700-5400 нэгж	240-700 цагийн нийтэд тустай ажил 6 сараас -1 жил	6 сараас -1 жил
6.	16.9 дүгээр зүйл. Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах	5400-27,000 нэгж 10,000-40,000	1-5 жил	1-5 жил 2-8 жил
7.	16.10 дугаар зүйл. Хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх <i>/Энэ хэсэгт 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/</i>	2700-5400 нэгж	240-700 цагийн нийтэд тустай ажил 6 сараас-1 жил	6 сараас-1 жил

ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬ

Хуулийн 9 дугаар зүйл. Хүүхдийн хүмүүжил, төлөвшил

9.1. Хүүхдийг хүмүүжүүлэх нь хүүхдэд бие хүний сайн сайхан шинж байдал зөв үйл, ёс суртахууны үнэт чанарыг төлөвшүүлэх тасралтгүй үйл ажиллагаа байх бөгөөд хүүхдийг хүмүүжүүлэхэд дараах чиглэлийг баримтална:

9.1.1. эцэг эхээ хайрлах, бусдыг хүндэтгэх, туслах;

9.1.2. эх орон, байгаль орчноо хайрлан хамгаалах;

9.1.3. зохих насанд нь сургуулийн өмнөх, бага, дунд боловсрол эзэмшүүлэх;

9.1.4. хууль ёсыг сахих, үндэсний өв уламжлалаа дээдлэн хүндэтгэх;

9.1.5. эрүүл мэнд болон өөрийгөө хамгаалах, амьдрах арга ухааны дадал, чадвар эзэмшүүлэх;

9.1.6. оюун ухаан, бие бялдар, авьяас чадвараа хөгжүүлэх.

ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬ

10 дугаар зүйл. Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үүрэг

10.1. Хүүхдийн эрхийг хангах талаар эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь доор дурдсан үүрэг хүлээнэ:

10.1.1. хүүхдэд гэр бүлдээ аз жаргалтай, хайр халамжтай, бүхий л талаар хөгжих орчинг бүрдүүлэх;

10.1.2. хүүхдээ хүмүүжүүлэх, харилцааны соёл төлөвшүүлэх;

10.1.3. хүүхдийн хөгжил, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах;

10.1.4. хүүхдийг сурган хүмүүжүүлэх, боловсрол эзэмших, авьяас чадварыг нь хөгжүүлэхэд сургууль, хүүхдийн болон бусад холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэдтэй хамтран ажиллах;

10.1.5. хүүхдийг хууль тогтоомжид заасан нийгмийн үйлчилгээнд хамруулах;

10.1.6. хүүхдийн нэр төр, эрүүл мэнд, хувийн нууцыг хадгалж, хувийн орон зайг хамгаалах;

10.1.7. хүүхдийг хүндэтгэн сонсож, шийдвэр гаргах;


10.1.8. хүүхдийг хөгжиж, төлөвшихэд нь дэмжин туслах;

10.1.9. хууль тогтоомжид заасны дагуу хүүхдийнхээ өмнөөс хариуцлага хүлээх;

10.1.10. хүүхдийг наад захын хэрэгцээт зүйлээр хангах;

10.2. Эцэг, эх тусдаа амьдрах, гэрлэлтээ цуцлуулсан нь тэднийг энэ зүйлийн 10.1-д заасан үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

Хүүхэд хамгааллын тухай хууль: Бодлого, эрх зүйн хүрээ





**НАСАНД ХҮРЭЭГҮЙ
ХҮНЭЭР ЭРХЛҮҮЛЭХИЙГ
ХОРИГЛОСОН АЖЛЫН
БАЙРНЫ ЖАГСААЛТ**

ЖАГСААЛТЫГ ШИНЭЧЛЭХ ШАЛТГААН, НӨХЦӨЛ

ХХТХ-ийн тухай ОУХБ-ын 182 дугаар конвенцийн 4 дүгээр зүйлийн 3-т заасны дагуу

Хүүхдийн эрхийн тухай конвенцийн хэрэгжилтэнд өгсөн зөвлөмжийн дагуу

АНУ-ын Төрийн Департаментын зөвлөмжийн дагуу

“Хурдан морины хаврын уралдаан дахь хүүхдийн эрх” судалгааны тайлангийн дүгнэлт зөвлөмжийн дагуу,

Хүүхдийн төлөө үндэсний газрын “Барилгын салбар дахь хүүхдийн хөдөлмөрийн асуудлыг тодорхойлох түргэвчилсэн судалгааны тайлан”-д дурдсаны дагуу

АЮУЛТАЙ АЖИЛ

№	Шалгуур үзүүлэлт	Нөхцөлүүд
1	Хүүхдийн нас	
2	Төрөл, шинж чанараараа хүүхдийн эрүүл мэнд, хөгжилд сөрөг нөлөө үзүүлэх	
3	Хүүхдэд үзүүлж болох эрсдэлийг нэмэгдүүлэх хүчин зүйл	Байгаль цаг агаарын, Ажлын нөхцөлийн
4	Хүүхдийн сэтгэл зүй, ёс суртахууны хувьд үзүүлэх нөлөөлөл	
5	Хүүхдийн суралцах үйл явцад нөлөөлөх байдал	
Монгол Улсын хууль тогтоомж, стандарт болон холбогдох конвенцийн ямар зүйл заалт зөрчигдөж байгаа эсэх		

ЖАГСААЛТЫГ ШИНЭЧИЛЭХДЭЭ:

- Жагсаалтын хамрах хүрээ зөвхөн албан салбараас гадна албан бус салбар, хувийн хэвшил, хөдөө аж ахуйн салбарыг хамарсан.
- ҮАМАТ-ын дагуу нэрлэсэн.
- Жагсаалтад тусгагдсан ажлын төрлүүд нь эдийн засгийн үйл ажиллагаа, ажлын байр, ажил, мэргэжлээр ялгавартай тусгасны зэрэгцээ хүүхдийн эрүүл мэнд, амь насанд учрах аюулын төрлийг нийтлэг, ажлын байрны орчин нөхцөл, үйлдвэрлэлийн процесс, салбарын онцлогтой уялдуулсан нь практикт хэрэглэхэд илүү хялбар, ойлгомжтой болсон.
- Жагсаалтыг шинэчлэх, шинээр оруулах ажлуудыг ажлын хэсгийн гишүүдийн судалгаа, дүгнэлтээс гадна Хөдөлмөрийн яамны газрын дарга нар, үндэсний болон олон улсын зөвлөхүүдийн санал зөвлөмж, эзэд, үйлдвэрчний байгууллагуудаас санал авсны үндсэн дээр боловсруулсан.

“НАСАНД ХҮРЭЭГҮЙ ХҮНИЙГ АЖИЛЛУУЛАХЫГ ХОРИГЛОСОН АЖЛЫН БАЙРНЫ ЖАГСААЛТ”-ЫГ ШИНЭЧИЛЖ ХҮҮХДИЙН АМЬ НАС ЭРҮҮЛ МЭНДЭД НОЦТОЙ ХОХИРОЛ УЧРУУЛЖ, СУРЧ БОЛОВСРОХ ЭРХИЙГ ЗӨРЧИЖ БУЙ ЗАРИМ АЖЛЫН ТӨРЛҮҮДИЙГ НЭМЖ ОРУУЛСАН. ҮҮНД:

- 1. Уул уурхай олборлолт болон барилгын салбарт ажиллах нь хүүхдийн амь нас эрүүл мэндэд хортой учир салбараар хориглосон. Харин үүнд мэргэжлийн дадлага олгох зорилгоор эцэг эх болон зохих шатны байгууллагын зөвшөөрөлтэйгээр дадлага удирдагчийн удирдлаган доор хийж буй ажлуудыг хамаарахгүйгээр зааж өгсөн.**

2. Боловсруулах үйлдвэрийн салбарт бүх төрлийн суурилагдсан болон механикжсан тоног төхөөрөмжүүд, технологийн зориулалттай болон ердийн машин механизмууд, байнгын гар ажиллагаатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг ашиглан үйл ажиллагаа явуулдаг үйлдвэрлэлийн дамжлагын бүх төрлийн ажил буюу үйлдвэрлэлийн орчинд ажиллахыг нь хориглосон.
3. Бусад бүх салбарт хүүхдэд аюултай ажлуудыг нь тодорхойлж, ажил мэргэжил, ажлын байраар оруулсан.
4. Өөрийн төрсөн гэр болон төрсөн ах эгч, эмээ өвөөгөөс бусад айлд амьдарч мал маллах гэдгийг хориглосон бөгөөд харин өөрийн гэр бүлдээ амьдарч бусад айлын малыг маллахыг хориглоогүй болно. (гэр бүлээрээ туслах малчин хийх)

5. Авто зам дээрх худалдаа үйлчилгээний ажил буюу хүүхдүүд авто машины замын голоор явж машинтай хүмүүст машины үнэртүүлэгч зардаг. Ингэснээр хүүхдүүд авто машинд дайруулах өндөр эрсдэлтэй. Харин худалдааны зах болон бусад газарт 15-аас дээш насны хүүхдүүд жижиг бараа зарах, зөвшөөрөгдөх хэмжээнд ачаа зөөх зэрэг хөнгөн ажлыг өдөрт зөвшөөрөгдсөн цагаар хийхийг хориглоогүй.
6. Жил бүрийн 11 сарын 1-ээс 5 сарын 1 хүртэлх хугацаанд хурдан морины сунгаан, үсэргээн, уралдаанд морь унуулах буюу өвөл хаврын морин уралдаанд насанд хүрээгүй хүнээр хурданы морь унуулахыг хориглосон бөгөөд зуны хугацаанд хурдан морь унахыг хориглоогүй болно.

7. Шөнийн цагаар болон архи мансууруулах ундаагаар үйлчилж буй газарт соёлын болон циркийн, ардын урлагийн үзүүлбэр үзүүлэх ажилд хүүхдүүдийг оролцуулахыг хориглосон.
8. Өөрийн төрсөн ах эгч, эмээ өвөөгийн гэрээс бусад айлд байрлан ажиллаж буй гэрийн үйлчлэгч, хүүхэд асрагч хийхийг хориглосон бөгөөд харин 15-аас дээш насны хүүхэд өдрийн цагаар зохих зөвшөөрөгдсөн цагаар тухайн айлдаа байрлахгүйгээр ажил эрхлэхийг хориглоогүй болно.
9. Зөгий үржүүлэгч, шувуун аж ахуйн ажилтан

Хүүхдийн хөдөлмөртэй холбоотой хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

Д/д	Хуулийн зүйл	Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага
1.	Хөдөлмөрийн тухай хуулийн 141 дүгээр зүйл. Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага	141.1. Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ. 141.2. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ. 141.3. Энэ хуулийг зөрчсөн үйлдлийн улмаас ажилтны эрүүл мэндэд гэм хор учирсан бол Иргэний хуулийн гэм хорын тухай холбогдох заалтаар хохирлыг нөхөн төлүүлнэ. 141.4. Ажилтны цалин хөлсийг тогтоосон хугацаанд олгоогүй, саатуулсан нь нотлогдсон тохиолдолд хожимдуулсан хоног тутамд 0,3 хувийн алданги ажил олгогчид шүүх ногдуулж, ажилтанд олгоно. /Энэ зүйлийг 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/
2.	Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйл. Хүүхдийн эрхийг зөрчих /2017 оны 05 дугаар сарын 11-ний өдөр Шинэчилсэн найруулга/	3. Хүүхдийг: 3.1. Өөрийнх нь ба эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрөлгүйгээр мэдээлэл, сурталчилгаанд ашигласан; 3.2. Бусад хэлбэрээр хууль бусаар нэрийг нь барьж, ашиг олох, эрүүл мэнд, амь нас, нэр хүндэд нь харшлах, эсхүл аюул учруулах тоглоом, наадамд оролцуулсан бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
3.	Эрүүгийн хуулийн 16.10 дугаар зүйл. Хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх	16.10 дугаар зүйл. 1. Хүүхдээр аюултай ажил, эрүүл мэнд, бие бялдар, оюун санаанд нь хохирол учруулахуйц хориглосон ажил, үйлчилгээ зориуд эрхлүүлсэн бол хоёр мянга долоон зуун нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. /Энэ хэсэгт 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

4.	Хүүхэд хамгааллын тухай хуулийн 24 дүгээр зүйл. <i>Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага</i>	24.1. Хүүхдийн эрхийн зөрчилд хүлээлгэх хариуцлагыг Зөрчлийн тухай хуулиар, хүүхдийн эсрэг гэмт хэрэгт оногдуулах ял, албадлагын арга хэмжээг Эрүүгийн хуулиар тус тус тодорхойлно.
5.	Хүүхдийн эрхийн тухай хуулийн 19 дүгээр зүйл. <i>Хүүхдийн эрхийн талаар мэдээлэл өгөх, гомдол, нэхэмжлэл гаргах</i>	19.1. Хүүхэд эрхээ зөрчигдсөн гэж үзвэл өөрөө болон эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, бусад иргэн, байгууллагаар уламжлан эрхээ хамгаалуулахаар хууль тогтоомжид заасан журмын дагуу гомдол, нэхэмжлэл гаргана. 19.2. Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хүүхэд гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн байгууллага, баг, сум, хорооны хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн, нийгмийн ажилтан нь хүүхдийн эрх зөрчигдсөн гэж үзвэл хуульд заасан журмын дагуу төрийн байгууллагад гомдол, хүсэлт, шүүхэд нэхэмжлэл, холбогдох албан тушаалтан, хуулийн этгээдэд хүсэлт, шаардлага гаргаж болно. 19.3. Хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийг шалган шийдвэрлэх, хүүхэд хамгаалахтай холбоотой харилцааг хуулиар зохицуулна.
6.	Зөрчлийн тухай хуулийн 10.16 дугаар зүйл. Хөдөлмөрийн тухай хууль зөрчих /2017 оны 05 дугаар сарын 11-ний өдөр шинэчилсэн найруулга/	10.16 дугаар зүйл. 2. Насанд хүрээгүй хүнээр зөвшөөрөгдсөн хэмжээнээс илүү хүнд ачааг өргүүлсэн, зөөлгөсөн, насанд хүрээгүй хүнийг шөнө, амралтын өдөр, эсхүл илүү цагаар ажиллуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

ЯАГААД ХАВРЫН МОРИН УРАЛДААНЫГ ХОРИГЛОСОН БЭ?

Үндэсний төв архивын материалд хийсэн судалгаанд /1803-1920/


Уралдаанч хүүхдийн эрүүл мэнд амь нас хохирох тохиолдолд эцэг эх уяачид хоорондоо тохиролцох, эмчилгээний зардал төлөх төдийгөөр өнгөрдөг, хэн нэгэн буруутай этгээдийг тогтоож хариуцлага хүлээлгэх эрх зүйн орчин дутмаг

Цаг агаарын нөхцөл байдал, уралдааны зохион байгуулалт, хүүхдийн насны байдал зэрэг нь эрсдлийг улам нэмэгдүүлдэг, хүнд тэвчишгүй хэлбэрт тооцогдох нөхцөлийг бий болгодог.

ЯАГААД ХАВРЫН МОРИН УРАЛДААНЫГ ХОРИГЛОСОН БЭ?

Уралдаанч хүүхдүүдийн ихэнх нь хурдан морийг сонирхлоороо унадаг гэх боловч тэдний ар гэрийн амьдралын түвшин, гэр бүлийн анхаарал халамж, боломж бололцооноос шалтгаалан энэ хөдөлмөрийг сонгож байна.

Өвөл хаврын уралдаанд хүүхдийг хичээл сургуулиас нь чөлөө авах таслуулах зэргээр хөндийрүүлснээс сурлагаар хоцордог, нилээн тохиолдолд сургууль завсардаж үлддэг жишээ олон бий.





ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ДЭЛХИЙН ЧИГ ХАНДЛАГА

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУД БА 2025 ОНД ХҮҮХДИЙН
ХӨДӨЛМӨРИЙН ТЭВЧИШГҮЙ ХЭЛБЭРҮҮДИЙГ УСТГАХ ЗОРИЛТ

ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨР

1. Хүүхдийн хөдөлмөрийг устгах эрх зүйн орчин
2. Тоо баримт
3. Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх арга зам



ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРИЙГ УСТГАХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

ХӨДӨЛМӨРИЙН НАСНЫ ДООД ХЯЗГААРЫН ТУХАЙ КОНВЕНЦ

Хөдөлмөр эрхлэх насны доод хязгаарын
тухай ОУХБ-ын 1973 оны 138-р конвенц,
146-р зөвлөмж

Конвенцийг ОУХБ-ын 187 гишүүн орноос 169 соёрхон баталсан.

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ БОЛОН АЖИЛД АВАХ НАСНЫ ДООД ХЯЗГААР

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ НАСНЫ ДООД ХЯЗГААР (Конвенцийн 2-р зүйл)

	ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ	ХӨГЖИЖ БУЙ ОРНУУДАД ОЛГОДДОГ тусгай нөхцөл
Насны доод хязгаар (2-р зүйл)	15 нас (суурь боловсрол эзэмших наснаас дээш)	14 нас
Сөрөг нөлөө үзүүлж болзошгүй ажлын онцлог болон нөхцөл (3-р зүйл)	18 нас (зарим үед 16 нас, тодорхой нөхцөл шаардана)	Тусгай нөхцөл
Хөнгөн хөдөлмөр (7-р зүйл)	13-15 нас	12-14 нас

ЗАЙЛШГҮЙ

ЗАЙЛШГҮЙ

СОНГОЛТОТ

АЮУЛТАЙ АЖИЛ (3.1, 3.3-р зүйл)

- Ажлын үндсэн шинж, нөхцөл нь хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай бүх төрлийн хөдөлмөр болон ажил эрхлэлт
- Хөдөлмөрийн насны доод хязгаар нь 18 байна.
- Өсвөр үеийнхний эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахууныг хамгаалсан, тухайн салбарын талаархи мэргэжлийн сургалтад хамруулж, зааварчилгаа өгсөн байх болзолтойгоор ажил олгогч, ажилчдын төлөөллийн байгууллагуудтай зөвшилцсөний үндсэн дээр арван зургаан наснаас хөдөлмөр эрхлэхийг зөвшөөрсөн тухай үндэсний хууль тогтоомж, журамд тусгаж эсхүл эрх бүхий байгууллага шийдвэр гаргаж болно.

ХӨНГӨН АЖИЛ (ЗҮЙЛ 7.1)

Арван гурваас арван таван насны хүүхдийг хөлсний эсхүл өөр төрлийн хөнгөн ажил эрхлүүлэхийг үндэсний хууль тогтоомж, журмаар зөвшөөрч болно. Үүнд:

(а) эрүүл мэнд, өсөлт хөгжилд хортой нөлөө үзүүлэхгүй:

ХӨНГӨН АЖИЛ (ЗҮЙЛ 7.1)

(б) **хичээлдээ суух**, эрх бүхий байгууллагаас баталсан мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрт хамрах болон **олсон мэдлэгээ ашиглах явцад нь саад учруулахгүй** байх шаардлагыг хангасан байх ёстой.

ШААРДЛАГАТАЙ БҮХ АРГА ХЭМЖЭЭ АВАХ (ЗҮЙЛ 9)

Эрх бүхий байгууллага нь:

- Энэхүү Конвенцийн заалтуудыг эрчимтэй хэрэгжүүлэхэд эрх бүхий байгууллага зарим төрлийн шийтгэл ногдуулах хэлбэрээр шаардлагатай бүх арга хэмжээ авна.
- Энэхүү Конвенцийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн заалтуудын биелэлтэнд хяналт тавих этгээдийг үндэсний хууль тогтоомж, журам эсхүл эрх бүхий байгууллага тогтооно.
- Үндэсний хууль тогтоомж, журам эсхүл эрх бүхий байгууллага ажил олгогчийн хөтөлж, бүрдүүлэх бүртгэлийн болон бусад баримт бичгийг тогтооно.

ҮНДЭСНИЙ БОДЛОГО ХЭРЭГЖҮҮЛЭХ (ЗҮЙЛ . 1)

Энэхүү Конвенц хүчин төгөлдөр үйлчлэх гишүүн улс бүр дотооддоо:

- хүүхдийн хөдөлмөрийг бүрмөсөн устгах үндэсний бодлогыг хэрэгжүүлж,
- хөдөлмөрийн насны доод хязгаарыг өсвөр үеийнхний бие бялдар болон оюун ухааны хөгжил бүрэн гүйцэд төлөвших насанд хүргэхээр аажмаар нэмэгдүүлэх үүрэг хүлээнэ.

ХҮҮХДИЙН ТЭВЧИШГҮЙ ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ КОНВЕНЦ

ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРИЙН ТЭВЧИШГҮЙ ХЭЛБЭРҮҮДИЙН ТУХАЙ ОУХБ-ЫН
1999 оны 182-р конвенц, 190-р зөвлөмж

**Конвенцийг ОУХБ-ын 187 гишүүн орноос 180 орон
соёрхон баталсан.**

ҮҮРЭГ

(1-р зүйл)

Энэхүү Конвенцийг соёрхон баталж буй гишүүн улс бүр хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг хориглох, устгахад чиглэсэн **ҮР ДҮНТЭЙ** арга хэмжээг **НЭН ДАРУЙ, ЯАРАЛТАЙ** авч хэрэгжүүлнэ.

“ХҮҮХЭД” ГЭСЭН НЭР ТОМЪЁО

(2-р зүйл)

Энэхүү Конвенцийн зорилгод нийцүүлэн “**хүүхэд**” гэсэн нэр томъёо нь **18 насанд хүрээгүй бүх хүнд** (хөвгүүд болон охид) (улс орны хөгжлийн түвшингээс үл хамааран) хамаарна:

ТОДОРХОЙЛОЛТ: ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРИЙН ТЭВЧИШГҮЙ ХЭЛБЭРҮҮД

(3-р зүйл)

(а) Боолчлолын бүх хэлбэр болон боолчлолтой төстэй дараах үйл ажиллагаа хамаарна.

- хүүхдийг худалдах;
- өрийн төлөөс болон хамжлагын албат болгох;
- хүчээр буюу албадан хөдөлмөрлүүлэх;
- зэвсэгт мөргөлдөөнд ашиглах зорилгоор хүчээр буюу албадан оролцуулах;

ТОДОРХОЙЛОЛТ:ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРИЙН ТЭВЧИШГҮЙ ХЭЛБЭРҮҮД

(б) хүүхдийг **биеэ үнэлэх, садар самуун сурталчилгааны үйлдвэрлэл** буюу **садар самуун үзүүлбэрт** ашиглах, зуучлах, санал болгох

(в) олон улсын холбогдох гэрээнд тодорхойлсноор **хүүхдийг мансууруулах бодис үйлдвэрлэх, хил дамжуулан худалдах зэрэг хууль бус үйл ажиллагаанд** ашиглах, зуучлах, санал болгох,

УЛС ОРОН БҮР ТОДОРХОЙЛОХ ЁСТОЙ:
ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРИЙН ТЭВЧИШГҮЙ ХЭЛБЭРҮҮД
АЮУЛТАЙ АЖИЛ

(г) ажлын шинж чанар, түүнийг гүйцэтгэх нөхцөл нь хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд хор нөлөө үзүүлэх ажил

182-Р КОНВЕНЦИЙН 4-Р ЗҮЙЛ.ХӨНГӨН АЖИЛ

- 3 дугаар зүйлийн (d) дэд хэсэгт заасан ажлын төрлийг **үндэсний хууль тогтоомжоор, эрх бүхий байгууллагаас,**
- эсхүл ажил олгогч болон ажилчдын байгууллагатай зөвшилцсөний дараа,
- холбогдох олон улсын хэм хэмжээ, ялангуяа Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай 1999 оны зөвлөмжийн 3, 4 дэх хэсгийн заалтыг харгалзан үзсэний үндсэн дээр **тогтооно.**

182-Р КОНВЕНЦИЙН 4-Р ЗҮЙЛ. АЮУЛТАЙ АЖИЛ

- Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу тогтоосон ажлын төрлүүдийн жагсаалтыг үе үе хянаж, шаардлагатай бол ажил олгогч болон ажилчдын байгууллагатай зөвшилцөн өөрчлөлт оруулна.

АЮУЛТАЙ АЖИЛ

ОУХБ-ын 190-р зөвлөмжийн 3-р хэсэг

- (а) Хүүхдийг бие махбодь, сэтгэл санаа, бэлгийн хүчирхийлэлд өртүүлж болзошгүй ажил;
- (б) Газрын гүнд, усан доор, хэт өндөр, эсвэл хэт давчуу орон зайд явагдах ажил;
- (в) Аюултай машин механизм, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлтэй ажиллах түүнийг гараар удирдах буюу хүнд ачаа бараа тээвэрлэх ажлууд;


АЮУЛТАЙ АЖИЛ ОУХБ-ЫН 190-Р ЗӨВЛӨМЖИЙН 3-Р ХЭСЭГ

(г) Аюултай химийн бодис хэрэгсэл, үйл ажиллагаа буюу эрүүл мэндэд хохирол учруулахуйц температур, дуу чимээний түвшин, чичрэлт доргилт зэрэг эрүүл бус орчинд ажиллах ажлууд;

(д) Уртасгасан цагаар, эсвэл шөнийн ээлжинд ажиллах, ажил олгогчийн байранд тодорхой шалтгаангүйгээр байрлуулж ажиллуулах.

ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨР: ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭ

Figure 1.1: Basic distinctions in ILO child labour standards




- * The minimum age for admission to employment or work is determined by national legislation and can be set at 14, 15 or 16 years.
- ** The minimum age at which light work is permissible can be set at 12 or 13 years.
- *** For example, household chores, work in family undertakings and work undertaken as part of education.


ТОО БАРИМТ




168 MILLION CHILDREN IN CHILD LABOUR



ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨР, АЮУЛТАЙ АЖИЛ ЭРХЭЛЖ БУЙ ХҮҮХДИЙН ТОО, ДЭЛХИЙН ХЭМЖЭЭНД




CHILD LABOUR IS PRESENT IN EVERY REGION




ХҮҮХЭД ХӨДӨЛМӨР ЭРХЭЛЖ БУЙ БАЙДАЛ, САЛБАРААР

Хүүхэд хөдөлмөр эрхэлж буй байдал, салбараар, 5-17 насны бүлэг, 2012 (%)




ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨР, СТАТУСААР

Хүүхэд хөдөлмөр эрхэлж буй байдал, 5-17 насны бүлэг, (%)



ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭ

Олон улс болон үндэсний түвшинд статистик мэдээллийг сайжруулах;
Асуудлыг олон талаас шийдсэн бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэх;
Нас, хүйсийн онцлогт тохирсон арга хэмжээ авах;

A decorative graphic at the bottom of the slide consisting of overlapping geometric shapes. On the left, there is a solid blue triangle pointing right. To its right is a larger triangle with a fine grid pattern, colored in a light blue-green hue, also pointing right. The rightmost portion of the bottom section is a solid, light green area.

ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭ (ҮРГЭЛЖЛЭЛ)

- Хөдөө аж ахуйд үргэлжлүүлэн анхаарлаа хандуулж, бусад салбаруудыг шинээр хамруулах,
- Мэдлэг, мэдээллийг цуглуулах, хяналт, үнэлгээг сайжруулах
- Олон улсын хамтын ажиллагаа, түншлэл

ОЛОН УЛСЫН ТҮВШИНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ БОДЛОГО АРГА ХЭМЖЭЭ

- 2010 оны Дэлхийн Үйл ажиллагааны төлөвлөгөө ба техникийн хамтын ажиллагааны тэргүүлэх чиглэл - <http://www.ilo.org/ipeinfo/product/download.do?type=document&id=10992>
- 2010 онд Гааг хотноо болсон Дэлхийн Хүүхдийн хөдөлмөрийн хурлаас баталсан Замын зураглал <http://www.ilo.org/ipeinfo/product/viewProduct.do?productId=13453>
- 2013 оны Хүүхдийн хөдөлмөрийн дэлхийн 3 дугаар чуулга уулзалт –Хүүхдийн хөдөлмөрийн тухай Бразилийн тунхаг
➤ <http://childlabour2013.org/the-brasilia-declaration-on-child-labour/>
- Хүүхдийн хөдөлмөрийн дэлхийн 4 дугаар чуулга уулзалт-Аргентин 2017

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУД

Дэлхий нийтээр Албадан хөдөлмөр, орчин үеийн боолчлол, хүний наймаа, хүүхдийн хөдөлмөрийн бүх төрлийн хэлбэрүүдийг устгахад нэгдэцгээе.



1. Бүх төрлийн ядуурлыг устгах
2. Тогтвортой хөдөө аж ахуйг дэмжин, хүнсний тэжээллэг чанар, аюулгүй байдлыг нэмэгдүүлэх, өлсгөлөнг зогсоох
3. Бүх насны хүмүүсийн эрүүл аж төрөх байдлыг хангах
4. Боловсрол эзэмшилт, боловсролын чанарыг нэмэгдүүлэх
5. Жендерийн эрх тэгш байдлыг хангах, охид, эмэгтэйчүүдийн эрхийг нэмэгдүүлэх
6. Цэвэр усны хангамжийг дээшлүүлэх
7. Найдвартай, тогтвортой, орчин үеийн эрчим хүчийг нэвтрүүлэх
8. ЭЗ-ийн өсөлтийг дэмжих, хөдөлмөр эрхлэлтийг хангалттай хөдөлмөрийн хөлсөөр хангах
9. Тогтвортой дэд бүтэц, үйлдвэрлэл, инновацийг дэмжих
10. Улс орнуудын баян чинээлгийн ялгааг багасгах
11. Хотуудыг аюулгүй, амар амгалан, тогтвортой байдлаар хангах
12. Тогтвортой үйлдэрлэл болон хэрэглээг хангах
13. Уур амьсгалын өөрчлөлт болон түүний ул мөрийн эсрэг арга хэмжээг авах
14. Далай тэнгисийн тогтвортой байдлыг хангах
15. Ой, хээрийг хамгаалж, цөлжилтийн эсрэг тэмцэх, биологийн төрөл зүйлийн хорогдлыг зогсоох
16. Энх тайван бүхий нийгмийг цогцлоох
17. Тогтвортой хөгжлийн төлөөх дэлхийн түншлэлийг сэргээн хадгалах.

SUSTAINABLE DEVELOPMENT GOALS



17 зорилт, 169 зорилго



Зорилт 8

Хүртээмжтэй, тогтвортой эдийн засгийн өсөлтийг дэмжиж, бүх нийтийг бүтээмжтэй, зохистой ажлын байраар хангахыг дэмжих



Зорилго 8.7


Албадан хөдөлмөр, орчин үеийн боолчлол, хүний наймааг зогсоох яаралтай, үр дүнтэй арга хэмжээ авах, хүүхдийг цэрэгт дайчлах, ашиглах зэрэг хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг хориглох, устгах, 2025 он гэхэд хүүхдийн хөдөлмөрийн бүх төрлийн хэлбэрүүдийг устгах.

Шалгуур үзүүлэлт 8.7.1

5-17 насны хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн эзлэх хувь хэмжээ, нас, хүйсээр (хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдээр эрхлэлтээр ангилсан)

ЗОРИЛТ 8.7

Албадан хөдөлмөр, орчин үеийн боолчлол, хүний наймааг зогсоох яаралтай, үр дүнтэй арга хэмжээ авах, хүүхдийг цэрэгт дайчлах, ашиглах зэрэг хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг хориглох, устгах, 2025 он гэхэд хүүхдийн хөдөлмөрийн бүх төрлийн хэлбэрүүдийг устгах.



16.2 Хүүхдийн эсрэг дарангуйлал, хүүхдийн мөлжлөг, хууль бус наймаа, хүчирхийллийн бүх хэлбэр, хүүхдийг тарчлан зовоох явдлыг зогсоох.

16.9 Бүх нийтээр хууль ёсны баримт бичиг, тухайлбал төрсний гэрчилгээтэй болох.

10.7 Сайтар төлөвлөсөн, менежментээр хангасан цагаачлалын бодлогын хүрээнд журамтай, аюулгүй, байнгын, хариуцлагатай цагаачлал болон хүн амын шилжилт хөдөлгөөнийг хэрэгжүүлэх.

10.3 Ялгаварлан гадуурхах хууль, бодлого, практикийг устгах, холбогдох хууль эрх зүй, бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх замаар адил боломжийг хангах, үр дүнгийн тэгш бус байдлыг бууруулах.


10.2 Бүх хүн амын нийгмийн, эдийн засгийн, улс төрийн эрх мэдэл, оролцоог нэмэгдүүлэх, ингэхдээ нас, хүйс, хөгжлийн бэрхшээл, арьс өнгө, үүсэл гарал, шашин, эдийн засаг болон бусад байдлыг үл харгалзах.

8.6 Хөдөлмөр, боловсрол, сургалтаас гадуур байгаа залуучуудын хувийг үлэмж бууруулах.

8.8 Хөдөлмөрийн эрхийг хамгаалах, бүх ажилчид, тухайлбал цагаач ажилчид, ялангуяа эмэгтэй цагаач ажилчид, түр ажил эрхэлж байгаа хүмүүсийн ажлын байрны аюулгүй, баталгаатай орчинг хангах.

1.1 Ядуурлын бүх хэлбэрийг бүрэн устгах

1.2 Үндэсний үзүүлэлтээр ядуурлын түвшинд амьдарч байгаа бүх насны эрэгтэй, эмэгтэй хүн, хүүхдийн тоог тэн хагасаас доошгүй хувиар бууруулах.



8.5 Бүх эрэгтэй, эмэгтэйчүүд, залуу болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бүрэн, үр бүтээмжтэй хөдөлмөр эрхлэлтэд хамруулах, зохистой ажлын байраар хангах, адил үнэлэмжтэй ажилд адил цалин хөлс олгох.

1.3 Амьжиргааны доод хэмжээг тогтоох зэрэг бүх нийтийг хамарсан нийгмийн хамгааллын тогтолцоо болон арга хэмжээг үндэсний нөхцөл байдалд нийцүүлэн хэрэгжүүлэх, ядуу болон эмзэг бүлгийнхнийг хамруулахад дорвитой ахиц гаргах.

4.1 Бүх охид, хөвгүүд үнэ төлбөргүй, тэгш, чанартай бага болон дунд боловсрол эзэмших, сургалтын зохих үр дүнд хүрэх нөхцөлийг хангах.

4.3 Бүх эрэгтэй, эмэгтэйчүүд хямд, чанартай техникийн, техник мэргэжлийн, гурван шатны, их сургуулийн боловсролд адил эрхтэй хамрагдах нөхцөлийг хангах.

4.4 Зохистой ажил хөдөлмөр, бизнес эрхлэх чадвартай, техникийн болон техник мэргэжлийн боловсролтой залуучууд, насанд хүрсэн хүмүүсийн тоог үлэмж нэмэгдүүлэх.

4.5 Боловсрол дахь жендэрийн тэгш бус байдлыг арилгах, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, уугуул ард иргэд, эмзэг өртөмтгий байдалд байгаа хүүхдүүд зэрэг эмзэг бүлгийнхэн бүх шатны боловсрол болон техник мэргэжлийн сургалтад тэгш хамрагдах нөхцөлийг хангах.

4.6 Бүх залуучууд, насанд хүрсэн эмэгтэй, эрэгтэйчүүдийн дийлэнх хэсэгт унших, бичих, тоолох мэдлэг олгох.

5.2 Олон нийт болон хувийн хэвшлийн салбарт бүх эмэгтэйчүүд, охидын эсрэг хүчирхийллийн бүх хэлбэр, тухайлбал хууль бус наймаа, бэлгийн болон бусад мөлжлөгийг устгах.

5.3 Бага насны хүүхдийг эрт болон албадан гэрлүүлэх, эмэгтэй хүний бэлэг эрхтнийг гэмтээх зэрэг хор хөнөөлтэй бүх үйлдлийг устгах.

5.4 Асран хүмүүжүүлэх болон гэрийн цалингүй ажил, хөдөлмөрийг олон нийтийн үйлчилгээ, дэд бүтэц, нийгмийн хамгааллын бодлогоор хүлээн зөвшөөрч үнэлэх, айл өрх болон гэр бүлд хариуцлагыг тэнцвэржүүлэх нөхцөлийг үндэсний онцлогийг харгалзан сайжруулах.



- **8.7 Түншлэл** нь Тогтвортой хөгжлийн 8.7-р зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн хамтын ажиллагаа юм.

Түншлэлийн зорилго: *НҮБ гишүүн орнуудад албадан хөдөлмөр, орчин үеийн боолчлол, хүний наймааг 2030 он гэхэд устгах, тэр дундаа хүүхдийг цэрэгт дайчлах, ашиглах зэрэг хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг 2025 он гэхэд бүрэн арилгахад чиглэсэн яаралтай, үр дүнтэй арга хэмжээ авахад нь бүх талаар дэмжлэг үзүүлэх.*



- Яаралтай арга хэмжээ авах шаардлагатай байна:
 - 21 сая хүүхэд, эрэгтэй, эмэгтэй хүмүүс албадан хөдөлмөр эрхэлж байна.
 - Хүүхдийн хөдөлмөрийн үзүүлэлт сүүлийн жилүүдэд буурч байгаа боловч дэлхийн хэмжэнэд 168 сая хүүхэд хөдөлмөр эрхэлсээр байна.
- Ази, номхон далайн орнуудад 11 сая хүн албадан хөдөлмөр эрхэлж, 5-17 насны 78 сая хүүхэд хөдөлмөр эрхэлж байна.

MILLIONS OF CHILDREN ARE AT INCREASED RISK OF ABUSE



Across the globe, nearly 50 million children have been uprooted.


28 million of them driven from their homes by conflicts, and millions more migrating in the hope of finding a better, safer life. All are at increased risk of forced labour, modern slavery, human trafficking and child labour.



50 сая хүүхэд дэлхий нийтийн хэмжээнд аюулд байна. Эдгээрээс 28 сая хүүхэд зөрчилдөөний улмаас орон гэрээсээ хол аюулгүй ирээдүйн төлөө дайжин амьдарч байна. Энэ нь тэднийг албадан хөдөлмөр, орчин үеийн боолчлол, хууль бус хүний наймаа, хүүхдийн хөдөлмөрт өртөх эрсдэлд орох нөхцөлийг бий болгодог байна.



- Тогтвортой хөгжлийн зорилтод хүрэхээр дэлхий нийтээр хичээж ажиллаж байгаа нь албадан хөдөлмөр, боолчлол, хүний наймаа, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгахад шинэ алхам болох юм.
- Байгууллагууд дан дангаар амжилттай ажиллаж байгаа боловч, хүчээ нэгтгэвэл улам их амжилтанд хүрэх боломж байна.
- Үйл ажиллагааны давхардлаас зайлсхийж, сайн туршлага, шилдэг шийдлийг түгээн дэлгэрүүлэх хэрэгтэй.
- Шинэ технологи: Мэдлэгээ хуваалцах шинэ боломж бий болж, үйл явдлыг тухай бүр хянах боломжтой боллоо.





АСУУДЛЫГ БОДЛОГОД ТУСГАХ – ХУРДАЦ – БОДЛОГЫН ДЭМЖЛЭГ

ЗУРАГЛАЛ

Асуудлыг бодлогод тусгах

ТХЗ-ыг хэрэгжүүлэхийн төлөө үндэсний бодлого, хөтөлбөрийг чиглүүлэх, төсвийн хуваарилалтад тусгах

Түргэвчлэх

Тулгамдсан асуудлуудад анхаарлаа хандуулах, тулгарч буй асуудал бэрхшээлийг шийдвэрлэхэд хамтран ажиллах, арга хэмжээг уялдуулах .

Бодлогын дэмжлэг

НҮБ –аас мэргэжлийн туслалцаа үзүүлэх

Хамтын ажиллагаа:Хууль тогтоох, ТББ, нийгмийн салбарын байгууллага, итгэл үнэмшилд суурилан байгуулагдсан байгууллага, хувийн сектор, олон нийттэй харилцах гэх мэт үндэсний хэмжээнд хамтын ажиллагааны хүрээг өргөжүүлэх.

Хариуцлага:НҮБ болон бодлого боловсруулагчид тавих хяналтын бүтэц, бодлогыг тодорхойлох.

Мэдээллийн сан: Гишүүн орнуудад Эх дэлхийгээ шинэчилье: 2030 он хүртэлх Тогтвортой Хөгжлийн Хөтөлбөрийн талаарх суурь тоо баримт, мэдээлэл өгөгдөл мэдээлэл цуглуулах, чадавхийг дээшлүүлэхэд түлхүү дэмжлэг үзүүлэх.

Implementation Guidance Areas

for mainstreaming the 2030 Agenda for Sustainable Development
and Tailoring the SDGs to National Contexts

1. Raising public awareness
2. Applying multi-stakeholder approaches
3. Tailoring SDGs to national, sub-national and local contexts
4. Creating horizontal policy coherence (breaking the silos)
5. Creating vertical policy coherence (*glocalizing* the agenda)
6. Budgeting for the future
7. Monitoring, reporting and accountability
8. Assessing risks and fostering adaptability



ТХЗ 8.7-г хэрэгжүүлэхэд дараах бэрхшээл тулгарч байна.

Дараах 3 гол саадыг даван туулах, устгахыг эрчимжүүлэх болон хурдасгах:

1. Богино хугацаанд хэрэгжүүлэх: Улс орнууд ТХЗ-ыг богино хугацаанд хэрэгжүүлэх, хүүхдийн хөдөлмөрийг устгах чиглэлээр яаралтай арга хэмжээ авч, тэдгээрийн уялдаа холбоог хангах нь чухал.



2. Туршлага солилцох: ТХЗ 8.7-н хүрээнд улс орнууд туршлагаа хоороондоо солилцох нь чухал. Олон нийтийн хүртээл болоогүй судалгаа, мэдээллийн сан байсаар байна. Эдгээр мэдээллийг нэг эх сурвалжаас авах хялбар механизм байхгүй байна.

3. Санхүүжүүлтийг нэмэх: Зорилгыг амжилттай хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн хувьд бэрхшээлтэй байна. Санхүүжилтийг хооронд нь уялдуулж чадахгүй байгаагаас нэгдсэн үр дүнд хүрч чадахгүй байх эрсдэл байна.


ОУХБ БАЙГУУЛЛАГЫН ХОЛБООТОНД ОРУУЛАХ ХУВЬ НЭМЭР

IPES+
АЙПЕК+

НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ



www.alliance87.org



www.50forfreedom.org